



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/52

Бат-Өлзий сум

Сайн дурын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд гал түймрийн аюул тохиолдсон үед гал унтраах, их хэмжээний газар нутаг хамрахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)

Н.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

А.Мягмардагва (Ойн инженер)

Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)

Д.Мөнх (Цахилгаан шугам сүлжээний салбарын эрхлэгч)

М.Баатарчулуун (Цахилгаан шугам сүлжээний салбарын техникч)

Г.Дашдондов (Ерөнхий боловсролын сургуулийн багш)

Д.Баярсайхан (Ерөнхий боловсролын сургуулийн багш)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

Т.Анхбаяр (Ерөнхий боловсролын сургуулийн сантехникч)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

М.Бат-Өлзий (Засаг даргын Тамгын газар жолооч)

2.Сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах сургалтад хамруулж, техник хэрэгслээр ханган, байнгын бэлэн байдалд бэлтгэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын "Гал унтраах баг шинээр байгуулах тухай" 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/178 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

20240329